



БОЛОВСРОЛ,  
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН,  
СПОРТЫН ЯАМ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД УХНААГИЙН ХҮРЭЛСҮХИЙН ИВЭЭЛ ДОР

# “ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ - ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛ” УЛСЫН ХОЁРДУГААР ЗӨВЛӨГӨӨН - 2018



## ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН СУРГАЛТЫН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨГӨӨ

Илтгэгч: М. Итгэл. Ph.D. Боловсролын хүрээлэн  
А. Энхтогтох. Боловсролын хүрээлэн



# ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН СУРГАЛТ, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЛААР БАРИМТЛАХ ЧИГЛЭЛ

## ХҮҮХЭД

ЕБС нь хүүхэд нэг бүрийн хөгжил, төлөвшил-хүмүүжил, хамгааллын төв байна.

СУРГАЛТ

СУРГАЛТЫГ ДЭМЖИХ ҮЙЛ  
АЖИЛЛАГАА

## СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Сургалт, сургалтыг дэмжих үйл ажиллагааг зохион байгуулахад баримтлах чиглэл



# ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ

## Өнөөгийн байдал

ЕБС-ийн удирдлагын түвшинд сургуулийн хөгжлийн төлөвлөгөө, төлөвлөлт болон эрх зүйн баримт бичгийн боловсруулалтыг сайжруулахад дэмжлэг хэрэгтэй.

## Бэрхшээл, асуудал

ЕБС-ийн удирдах ажилтны томилгоо, тогтвортой байдал алдагдсан тул тэдний чадавх, сургуулийн хөгжлийн төлөвлөлт, эрх зүйн зохицуулалт оновчтой бус байна.

## Шийдэх арга зам

- Боловсролын хуульд сургалтын бодлогыг ямар субъект тодорхойлдог байх статусыг тодорхой болгоно.
- Сургуулийн бүрэн эрхтэй холбоотой одоо мөрдөгдөж буй дүрэм, журмуудыг илүү ойлгомжтой болгоно.



# СУРГУУЛИЙН ЯЛГААТАЙ БАЙДАЛ

## Өнөөгийн байдал

- 2017-2018 оны хичээлийн жилд 173 бүлэг III ээлжинд хичээллэж байгаагаас үүдэн сурагчийн сургууль дээр байх цаг (5) бага байна.
- Дэлхийн улс орнууд нэг өдрийн сургалт болон хичээлээс гадуурх үйл ажиллагаанд 5.5-8 цаг зарцуулж байна.

## Бэрхшээл, асуудал

Хот, хөдөөгийн болон сургуулийн ээлжийн ялгаатай байдлаас үүдэн ЕБС нь сургалтын болон бусад үйл ажиллагаагаар сурагчдыг хөгжүүлэх, төлөвшүүлэх, хүмүүжүүлэх зэрэг сургалтын чанарыг илтгэх зарчим, шалгуурын тогтолцоог бүрдүүлж чадахгүй байна.

## Шийдэх арга зам

-Сургалт, үйл ажиллагааг бүхэлд нь санхүүжүүлдэг тогтолцоонд шилжих нь сурагчийн хөгжил, төлөвшил-хүмүүжил, хүүхэд хамгаалалд сургуулийн үүрэг, оролцоог нэмэгдүүлэх үндэслэл болно.



# СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

## Өнөөгийн байдал

- Шинээр үзэж судлах хичээл, агуулга нэмэгдэх тохиолдол гарч байна.
- Зарим хичээл үйл ажиллагааг 1 цагаар судалж байна.
- Ахлах ангийн сургалтын төлөвлөгөөнд сонгон судлах хичээлийн тоо цөөн, сонгон судлах цаг бага байна.
- Сургалтын хөтөлбөрийг үнэлэх шалгуур, шаардлагыг боловсруулан практикт нэвтрүүлээд байна.

## Бэрхшээл, асуудал

- Сурагчийн өдрийн ачаалал их байгаа тул нэмэлт хичээл, агуулгыг багтаах боломж хязгаарлагдмал.
- Сургуулийн ялгаатай байдлаас хамааралтай сонголттой, уян хатан сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр хэрэгжих боломж бага.
- Сургалтын хөтөлбөрийг төлөвлөх, боловсруулах, турших, хэрэгжүүлэх үе шатуудад үнэлгээ хийх тогтолцоо бүрдээгүй байна.

## Шийдэх арга зам

- Шинэ хичээл, агуулгыг сургалт, үйл ажиллагаанд тусган хэрэгжүүлэх боломжийг эрэлхийлж, багш бэлтгэдэг тогтолцоотой уялдуулна.
- Сурагчийн сонголтод суурилсан, үр дүнтэй сургалтын төлөвлөгөөг боловсруулж мөрдөнө.
- Сургалтын хөтөлбөрийн хөгжил, хэрэгжилтийн судалгааг тогтмолжуулан түүний өөрчлөлт, хөгжүүлэлтийг эрдэм шинжилгээний үндэслэлтэй тодорхойлдог болгоно.



# СУРГУУЛЬ БОЛОН СУРАГЧИЙН АЧААЛАЛ

## Өнөөгийн байдал

- Олон хичээлийг бага цагт судлаж байна.
- Улаанбаатар хотод хамгийн их буюу нэг бүлэгт дунджаар 40 сурагч, бага ангид 50 сурагч хичээллэж байна.

## Бэрхшээл, асуудал

- Сурагч олон хичээлийг бага цагт судлаж байгаа нь тэдний ачааллыг нэмэгдүүлж байна.
- Хот, хөдөөгийн амьдрал, сургуулийн байршил, хүүхдийн тоо зэргээс шалтгаалан сургуулийн ачаалал, бүлэг дүүргэлт ялгаатай байна.

## Шийдэх арга зам

Сургуулийг нэг ээлжинд шилжүүлэх, хичээлийн үргэлжлэх хугацааг 5 минутаар уртасгах боломжийг судална.



# СУРГУУЛИЙН СОЁЛ

## Өнөөгийн байдал

Сургуулийн соёл, уур амьсгалтай холбоотой зарим заалтуудыг Боловсролын багц хууль, Хүүхдэд Ээлтэй Сургуулийн бодлого (2004), “Боловсрол” Үндэсний хөтөлбөр (2009), Ерөнхий боловсролын сургуулийн үлгэрчилсэн дүрэм (2010), Ерөнхий боловсролын сургууль болон цэцэрлэгийн багшийн ёс зүйн дүрэм (2007) зэрэг эрх зүйн баримт бичгүүдэд тусгаж, зохицуулж ирсэн.

## Бэрхшээл, асуудал

Сургуулиуд өөрийн онцлогт тохируулан сургуулийн соёлыг эрхэмлэж байгаа боловч цаашид сургуулийн соёл, менежментийг шинэ парадигмаар тодорхойлох шаардлага гарч байна.

## Шийдэх арга зам

- Сургуулийн соёлын хэв шинжийг бодитой тодорхойлж хөгжүүлнэ.
- Сургуульд баримтлах зарчимд үндэслэн сургуулийн үнэт зүйл, заавал мөрдөх хэм хэмжээг шинээр тодорхойлно.
- Сургалтад оролцогчдын эрх, үүрэг, оролцоо, хандлагыг хүүхдийн хөгжил, төлөвшил-хүмүүжил, хамгаалалд чиглүүлнэ.



# ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭТ БОЛОВСРОЛ

*Өнөөгийн нөхцөл байдал,  
бэрхшээл, асуудал*

Тэгш хамран сургах буюу тусгай хэрэгцээ шаардлагатай сурагчдын хэрэгцээнд нийцсэн үндэсний сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсруулж байгаагүй, сургуулийн хөтөлбөрөөр хичээллэж байна.

*Шийдэх арга зам*

Тэгш хамран сургах буюу тусгай хэрэгцээ шаардлагатай сурагчдын хэрэгцээнд нийцсэн ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ. Тусгай хэрэгцээт боловсрол олгодог сургуулийн үнэлгээний шинэчлэлийг эхлүүлнэ.





# ҮНЭЛГЭЭ

## Өнөөгийн байдал

Багшийн үнэлгээ субъектив нөлөөлөл ихтэй байна. Тухайн сурагчийн дүн ҮII, ҮIII, IX ангидаа ерөнхийдөө ойролцоо түвшинд байснаа төгсөх ангид дүн нь илэрхий өндөр байх тохиолдол түгээмэл байна.

## Бэрхшээл, асуудал

Үнэлгээний зорилгод нийцсэн үнэлэх тогтолцоо үндэсний болон сургуулийн түвшинд хэрэгжиж чадахгүй байгаа нь сурагчийн дүн бодитой биш байхад нөлөөлж байна.

## Шийдэх арга зам

- Сургууль үнэлгээний оношлох үүрэгт ач холбогдол өгч, хүмүүнлэг байх зарчмыг баримтална.
- Сурагчдын үнэлгээний талаарх багш нарын мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх, үнэлгээний олон төрлийн аргазүйд сургах, багш бэлтгэх болон багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтын хөтөлбөрт үнэлгээний асуудлыг онцгойлон авч үзнэ.



АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА.